



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/16

Амардалай

Г Сумын Гамшгаас хамгаалах удирдлага, ерөнхий
мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Сумын Онцгой байдлын болон гамшгаас хамгаалах мэргэжлийн анги удирдлагын бие бүрэлдэхүүнийг 1-р хавсралтаар, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг 2-р хавсралтаар тус тус томилгоожуулан баталсугай.

Хоёр: Учирч болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын болон гамшгаас хамгаалах Мэргэжлийн ангийн дарга /С.Нарантунгалаг/-т үүрэг болгосугай.

Гурав: Сумын Засаг даргын 2018 оны 01-р сарын 05 ны өдрийн А/05 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Б ИШ-ЁНДОН

4890100045